



Цагдаагийн ерөнхий газар



Гадаад хүнд зориулсан ГЭМТХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРТҮЙЛЭХ ЭСАВАР



Цагдаагийн ерөнхий газар



Агуулга

Мэдэгдэхгүйгээр үйлдэгдэхэд амархан гэмт хэрэг	02
Өдөр тутмын амьдралд үүсэж болох гэмт хэргээс сэргийлэх болон хариу арга хэмжээ авах нь	05
Гэмт хэргийг мэдэгдэх арга	09
Тусламж хүсэх утасны дугаар	13
Оршин суух эрх бүхий гадаад хүнийг дэмжих бодлого	15

Мэдэгдэхгүйгээр үйлдэгдэхэд амархан гэмт хэрэг



01 Хутга, төмөр саваа, төмөр хөрөө гэх мэт хүний амь нас, бие махбодод том хохирол учруулах боломжтой мэсийг тодорхой шалтгаангүйгээр биедээ авч явж болохгүй.

- Хүчирхийлэх, гэмтээх, сүрдүүлэх, баривчилах, хорих, албадах, заналхийлэх зэрэг зорилгоор мэс агуулж яваа тохиолдолд хүнд шийтгэл оногдуулна.
- Олон нийтийн социал сүлжээнүүд дээр "Мэс ашиглана гэх зэрэг аллагын гаралтай урьдчилсан мэдэгдэл" оруулсан тохиолдолд шийтгэл оногдуулна.

02 Мансууруулах бодис авч явах, найруулах, үйлдвэрлэх, хууль бусаар нэвтрүүлэх үйлдэлд хүнд шийтгэл оногдуулах ба албадан хорих шаардлага бүхий гэмт хэрэгтэнд шилжинэ.

- Мансууруулах бодист хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм, навчин тамхийг ерөнхийд нь хамруулна
- Цагдаагийн ерөнхий газар ◇Хууль бус мансууруулах бодис нийлүүлэх, ◇Гадаад иргэн мансууруулах бодиссурталчлах, ◇Интернет (хар веб), олон нийтийн социал сүлжээ зэргийг ашиглан мансууруулах бодис сурталчлах" зэргийг өндөр гэмт хэрэгт багтаан журамлана.
- Ялангуяа олон улсын шуудан, илгээмж зэргээр дамжуулан мансууруулах бодисыг хууль бусаар нэвтрүүлж улс дотор худалдсан тохиолдолд хүнд шийтгэл оногдуулна.

03 Хууль дүрмийг дагахгүйгээр өөрийн эд хөрөнгөө дэнчин тавьж ялж ялагдах тоглоомоор уралдах явдал нь бооцоо тавих үйлдэл бөгөөд шийтгэл оногдуулна.

- Түүнчлэн бооцоо тавих газраар хангаж өгч буй тохиолдолд ч бас бооцоот үйлдэл хийж байгаад тооцож хүнд шийтгэл оногдуулна.

04 Хууль бус зураг авалт, бэлгийн дарамт учруулах зэрэгт хамаарах үйлдлүүдэд хүнд шийтгэл оногдуулна.

- Бие махбодод ойртоогүй ч, 1. Интернет, гар утас зэргээр бэлгийн дарамт үзүүлэх, зөвүүлэл төрүүлсэн үг, зураг дамжуулах үйлдэл, 2. хэн нэгний бие махбодын зургийг зөвшөөрөлгүйгээр авах, түгээх үйлдэл, 3. хууль бусаар авсан зураг биедээ авч явах, худалдаж авах, үзэх зэрэг үйлдлүүд нь гэмт хэрэг юм.

05 Хэн нэгний үзэл бодолд татагдаж тодорхой шалтгаангүйгээр хэн нэгэнд болон тухайн хүний хамтран амьдрагч, гэр бүлийнхэнд нь ойртох аргаар мэдээллийн сүлжээг нь ашиглаж айдас, түгшүүртэй байдал бий болгох үйлдэл нь хэн нэгний нууцаар дагах явдал ба хүнд шийтгэл оногдуулна.

06 Зам дээр зогсож байгаа дугуй зэрэг нь эзэнгүй бараа мэт харагдаж, авч явсан тохиолдолд хулгай, эд хөрөнгө завшсан гэмт хэргээр шийтгэл оногдуулах боломжтой.

07 Санхүүгийн байгууллагад хандахгүйгээр хувь хүмүүс хоорондын худалдаа, наймаагаар дамжуулан гадаад гүйлгээ хийх үйлдэлд гадаад валютын гүйлгээний тухай хуулийг зөрчсөн гэх заалтаар шийтгэл оногдуулна.

08 17-оос дээш насны гадаад хүн үргэлж гадаад паспорт, гадаад иргэний үнэмлэх зэргийг биедээ авч явах шаардлагатай бөгөөд авч яваагүй тохиолдолд торгууль (1 сая воноос доош) оногдуулна.

- Хэрвээ өөр хүний үнэмлэхийг ашиглах эсвэл иргэний бүртгэлээ залилах гэж оролдсон тохиолдолд, хэргэм зэрэгт шаталсан байдлаар саад учруулсан гэмт хэргээр шийтгэл оногдуулна.

09 Жолооны үнэмлэх авалгүйгээр машин, мотоцикл, цахилгаан моторт скүтэр зэргийг жолоодвол жолооны үнэмлэхгүйгээр жолоо барьсан гэмт хэргээр шийтгэл оногдуулна.

- Жолоо барьж байх үедээ суудлын бүс бүслээгүй, хамгаалалтын малгай өмсөөгүй тохиолдолд торгуулийн мөнгө оногдуулна.

- Цахилгаан моторт скүтэрийг 2 ба түүнээс дээш хүн унасан тохиолдолд торгуулийн мөнгө оногдуулна.

- Согтууруулах ундаа уугаад жолоо барих тохиолдолд шийтгэл оногдуулна.

- Хуулийн дагуу өөрийн нэр дээрээ шилжүүлээгүй машин жолоодох тохиолдолд шийтгэл оногдуулна.

10 Үндсэн дэг журмыг зөрчсөн тохиолдолд ч торгуулийн мөнгө болон шийтгэл зэргийг оногдуулах тул болгоомжтой байх хэрэгтэй.


- Тамхины иш, хальс, хог зэргийг хамаагүй хаяж болохгүй.

- Олон нийтийн газар хамаагүй шүлсээ хаяж, тамхи татах хоритой газар тамхи татаж болохгүй.

- Зам хөндлөн гарахдаа гүүр болон явган хүний гарцаар (ногоон гэрэл) гарах хэрэгтэй.

- Тодорхой шалтгаангүйгээр зам таглах, хэрүүл өдөх, олноороо цуглаж хүн хөөх гэх мэт айдас төрүүлэхүйц үг, үйлдэл зэргээр хэн нэгнийг түгшүртэй байдалд оруулж, санаатайгаар уур уцаарыг нь хүргэх үйлдэл хийж болохгүй.

Өдөр тутмын амьдралд үүсэж болох гэмт хэргээс сэргийлэх болон хариу арга хэмжээ авах нь



01 Залилан (Хууль бус сүлжээний бүтээгдэхүүн борлуулах, утсаар санхүүгийн залилан хийх, смишинг, интернетээр залилан хийх гэх мэт)

- **Утсаар санхүүгийн залилан хийх** | Мөрдөн байцаах газар эсвэл санхүүгийн байгууллагын дүр эсгэж хэн нэгнийг луйвардаж мөнгө авах санхүүгийн том залиланг хэлнэ.

- Дансаар шилжүүлэх, бэлэн мөнгө дамжуулаад өг гэж шаардах, данс, карт, иргэний бүртгэлийн дугаар зэрэг хувийн мэдээллийг шаардах тохиолдолд яасан ч хариулж болохгүй.
- Хохирол учирсан тохиолдолд шууд цагдаад мэдэгдвэл санхүүгийн байгууллага руу холбогдож түр хугацаанд дансыг зогсоох аргаар тусалж өгнө.
- Залилангийн байгууллагын дэд байгууллагууд болж ажилласан бэлэн мөнгө шилжүүлэх газар, дуудлагын төвийн ажилчид зэргийг ч хам хэрэгтэн гэж үзэж шийтгэл оногдуулна.

Voice Phishing хохиролын жишээ

- Гэр бүл (хүүхэд) утсаа авахгүй нөхцөл байдал үүсгээд, барьцаалсан гэж хэлж мөнгө шаардах
- Прокурор, цагдаа гэх мэт мөрдөн байцаах газрын дүр эсгэж гэмт хэрэгт хам хэрэгтэн болсон, хувийн мэдээлэл алдагдсан гэж хэлээд мөнгө шаардах
- Санхүүгийн байгууллагын дүр эсгэж зээл гаргаж өгнө гэж хэлээд үндсэн зээлийн хэмжээний буцаан төлөлт, шимтгэл зэргээр мөнгө шаардах
- Карт, болон үүрэн телефоны байгууллагын дүр эсгэж төлбөрийн хугацаа хэтрэлт гэж хэлж мөнгө шаардах

- **Смишинг** | Хакер аппликэйшний линктэй мессеж (мэйл) утас руу явуулж тухайн аппликэйшнг татуулж санхүүгийн мэдээлэл (хувь хүний мэдээлэл) хулгайлдаг гэмт хэрэг.

- Танил хүнээс ирсэн мессеж байсан ч интернет линк агуулагдсан байвал дарж орохынхоо өмнө шалгаж, утасныхаа аюулгүй байдлын тохиргоог нэмэгдүүлж хохирол амсхаас сэргийлэх хэрэгтэй.

- **Интернет худалдааны залилан** | Барааны үнийг шилжүүлсэн ч барааг илгээхгүй эсвэл шал өөр барааг илгээх төрлийн гэмт хэрэг.

- Интернетээр хувь хүмүүс хоорондоо худалдаа хийхдээ аюулгүй худалдааны сайтыг ашиглаж худалдаа хийхийн өмнө нөгөө хүнийхээ мэдээллийг (утас, дансны дугаар) шалгах хэрэгтэй.
- Цагдаагийн ерөнхий газар (www.police.go.kr) болон цахим цагдаа (утасны аппликэйшн)-аар дамжуулж интернет залилангийн хохиролын талаар мэдээлэл байгаа эсэхийг хайх эсвэл хохиролоо мэдэгдэх боломжтой.

- **Хууль бус сүлжээний бизнес** | Энгийн, жижиг хэмжээтэй борлуулалтын үе шатыг дамжихгүйгээр хэрэглэгч өөрөө худалдагч болж бараа зарах үйлдэл.

- Богино хугацаанд өндөр ашиг олох зорилгоор гишүүн болон хөрөнгө оруулагчдыг цуглуулж, урьдчилан авсан бараагаа хүчээр шахах, зээлээр авахуулах зэргээр шаардах, бараагаа чанартай бараа мэт худал хуурмаг, хэтрүүлэгтэй сурталчилгаа хийж үнэтэйгээр зарах тохиолдолд бараа худалдаж авахаас болон тухайн байгууллагад элсэн орохоос татгалзана уу.

Хуулийн дагуу бүртгэлтэй байгууллага эсэхийг лавлах

- | | |
|---|---|
| - Шударга, эвэ худалдааны нийгэмлэг | www.ftc.go.kr , 1670-0007 (Үнэтэй) |
| - Шууд худалдааны харилцан туслалцааны нийгэмлэг | www.macco.or.kr , 02-566-1202 |
| - Солонгос тусгай эрэлтэт бараа худалдааны харилцан туслалцааны нийгэмлэг | www.kossa.or.kr , 02-2058-0831~8 |

02 Гэр бүлийн хүчирхийлэл

Гэр бүлийн хүчирхийлэл | Эхнэр нөхөр, аав ээж хүүхэд, ах дүү болон бусад хамтран амьдарч буй гэр бүлийг хамруулсан гишүүд дундаас нэг хүн өөр гишүүндээ санаатайгаар бие махбодын хҮЧ ашиглах, сэтгэцийн дарамт зэргээр өвдөлт мэдрүүлэх үйлдлийг хэлнэ.

- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эргэлзэхгүйгээр цагдаа болон хамаатан садан, хөрш, найздаа нөхцөл байдлыг мэдэгдэж тусламж гуйна.

※ Зураг, эмчийн онош гэх мэт хүчирхийлэл үйлдсэнг нотлох баримтыг олж аваад, эмгэгтэйчүүдийн байгууллага, амрах газар гэх мэт гэр бүлийн хүчирхийллийн эсрэг мэргэжлийн зөвлөгөө өгдөг байгууллагад хандаж зөвлөгөө авах хэрэгтэй. (Эмгэгтэйчүүдийн яаралтай зөвлөгөөний утас 1366 / Данүри дуудлагын төв 1577-1366)

03 Бэлгийн хүчирхийлэл

- **Бэлгийн хүчирхийлэл** | Хэн нэгэнд сэтгэл татагдаж хүчээр бҮХ төрлийн бэлгийн гаралтай үйлдлүүдээр бие махбод, хэл, сэтгэцийн гаралтай хүчирхийллийг үйлдэх томоохон гэмт хэргийн ойлголт.

- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд 112 дугаарт залгаж мэдэгдэнэ үү. (Мэдэгдэхийн өмнө усанд оролгүйгээр өмсөж байсан хувцасаа тэр чигээр нь хадгаласан тохиолдолд гэмт хэрэгтэнг барихад туслалцаа үзүүлнэ)
- Ойр тойронд чинь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүн байвал яриаг нь сонсож өгч, цагдаад заавал мэдэгдэнэ үү.
- Цагдаагаас гадна **"Эмгэгтэйчүүдийн яаралтай зөвлөгөөний утас 1366", "Данүри дуудлагын төв 1577-1366"** зэрэгт холбогдож зөвлөгөө авах боломжтой.

- **Дижитал бэлгийн хүчирхийлэл** | Бэлгийн хүслээ хангахын тулд ичгэвэрт байдалд орох боломжтой хүний биеийн зураг нууцаар авах, сүрдүүлэх, албадан хүчээр зураг авах, түүнийгээ зөвшөөрөлгүйгээр тарааж, түүгээх явдлыг хэлнэ.

- Дижитал бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд баримт нотолгоог устгалгүйгээр хадгалж аваад цагдаад хохирол учирсан гэх мэдэгдэлтэйгээ хамт мэдэгдэнэ үү.

04 Болзооны хүчирхийлэл

- **Болзооны хүчирхийлэл** | үерхлийн харилцаанд гарах хүчирхийллийн гаралтай бие махбод, сэтгэцийн хүчирхийлэл ч бас болзооны хүчирхийлэлд хамраг дана.
- Болзооны хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эргэлзэхгүйгээр цаг даа болон хамаатан садан, хөрш, найздаа нөхцөл байдлыг мэдэгдэж тусламж гуйна.

05 Сургуулийн хүчирхийлэл

- **Сургуулийн хүчирхийлэл** | Сургууль дотор сурагчдыг хүчирхийлэх, сүрдүүлэх, гадуурхах зэргээр бие махбод, сэтгэц, эд хөрөнгийн хохирол учруулах үйлдэл.
- Сургуулийн хүчирхийллээс хохирол амссан тохиолдолд эргэлзэлгүйгээр багш, эцэг эх, цагдаад мэдэгдэхээрэгтэй.
- Хүмүүс их явдаггүй нарийн гудам, аюултай газраас аль болох зайлсхийж, үнэт эдлэлээ алдах гэх мэт хохирол амссан тохиолдолд заавал цагдаад мэдэгдэж идэвхтэй арга хэмжээ авах шаардлагатай.


06 Хүүхэд алга болохоос сэргийлэх

- **Алга болсон хүүхэд** | Хар тамхи татах, уруу татах, уруу татагдах, осолд орох, зугтах, төөрөх гэх мэт шалтгаанаар асран хамгаалагчаасаа холдож алга болсон 18-аас доош насны жоохон хүүхэд.
- Танихгүй хүн танидаг мэт царайлж дагуулж явах, хүчээр дагуулж явах гэж оролдох үед чанга дуугаар чарлаж ойр хавийн хүмүүсээсээ тусламж гуйхыг зааж өгнө үү.
- Хүүхдэд өөрийнх нь нэр, нас, хаяг, утасны дугаар, аав ээжийнх нь нэр зэргийг мартагдахгүйгээр зааж өгч, гадуур гарсан тохиолдолд ямар хувцас өмссөн байгааг нь санах хэрэгтэй.
- Ялангуяа гарын хээ гэх мэт өмнө нь бүртгүүлсэн бүртгэл зэргийг ашиглан хамгийн ойр байрлах цагдаагийн газарт очиж хүүхдийн бие махбодын онцлог шинж зэргийг хэлж системд бүртгүүлэх боломжтой.

Гэмт хэргийг мэдэгдэх арга



01 Гэмт хэргийг гэрчлэх, эсвэл хохирол амссан тохиолдолд 112 дугаарт мэдэгдэж цагдаагийн тусламжийг хурдан авах боломжтой.



02 Солонгос хэл хараахан бүрэн сураагүй байгаа гадаад хүнд гэмт хэрэг (хохирол) мэдэгдэх болон санал, гомдол хэлэхэд зориулагдсан орчуулгийн үйлчилгээг хэрэгжүүлж байгаа.

- Гэмт хэргийг гэрчлэх эсвэл хохирол амссан тохиолдолд 112 дугаарт мэдэгдэх, эсвэл тухайн газар байгаа цагдаагийн ажилтанд цагдаагийн ажилтан-орчуулагч-мэдээлэгч гэсэн 3 шатлалт орчуулгийн үйлчилгээг хүссэн тохиолдолд туслалцаа авах боломжтой.

Орчуулгийн байгууллага	Тайлбар
Цагдаагийн ерөнхий газрын 112 орчуулга	<ul style="list-style-type: none"> • Удирдах байгууллага : Цагдаагийн ерөнхий газар • Үйлчилгээний цаг : 3 шатлалт орчуулга боломжтой / ажлын өдөр • Орчуулах хэл : Англи, Хятад (2 хэл)
Жуулчдын орчуулгийн мэдээллийн нэгдсэн утас (1330)	<ul style="list-style-type: none"> • Удирдах байгууллага : Солонгосын аялал жуулчлалын консул • Үйлчилгээний цаг : 3 шатлалт орчуулга боломжтой / Англи, Хятад, Япон хэл 24 цаг / бусад 5 хэл 08-19 цаг х'ртэл (365 өдөр) • Орчуулах хэл : Англи, Хятад, Япон, Орос, Вьетнам, Тайланд, Малайз, Индонези хэл (8 хэл)
Данүри дуудлагын төв (1577-1366)	<ul style="list-style-type: none"> • Удирдах байгууллага : Эмэгтэйчүүд, гэр бүлийн яам • Үйлчилгээний цаг : 3 шатлалт орчуулга боломжтой / Англи, Хятад, Вьетнам, Филиппин хэл 24 цаг / бусад 9 хэл 08-21 цаг х'ртэл (365 өдөр) • Орчуулах хэл : Англи, Хятад, Япон, Орос, Вьетнам, Тайланд, Монгол, Филиппин, Камбодж, Узбек, Лаос, Непал хэл (12 хэл)
Гадаад хүний нэгдсэн мэдээллийн төвийн утас (1345)	<ul style="list-style-type: none"> • Удирдах байгууллага : Хууль зүйн яамны харьяа хилээр орж гарах, гадаад иргэнийг удирдах төв байгууллага • Үйлчилгээний цаг : 3 шатлалт орчуулга боломжтой / Англи, Хятад хэл 09-22 цаг / бусад 17 хэл 09-18 цаг х'ртэл (Ажлын өдөр) • Орчуулах хэл : Англи, Хятад, Япон, Орос, Вьетнам, Тайланд, Индонези, Монгол, Филиппин, Камбодж, Араб, Непал, Франц, Испани, Мьянмарь, Бангладеш, Шри Ланка, Пакистан, Герман хэл (19 хэл)
BBB Солонгос (1588-5644)	<ul style="list-style-type: none"> • Удирдах байгууллага : Би Ён Ри нэгдмэл хуулийн этгээд • Үйлчилгээний цаг : 3 шатлалт орчуулга боломжтой (аппликэйшн) / 24 цаг (365 өдөр) • Орчуулах хэл : Англи, Хятад, Япон, Орос, Вьетнам, Тайланд, Малайз, Индонези, Монгол, Араб, Франц, Испани, Протугал, Швед, Финланд, Итали, Герман, Турк, Энэтхэг, Свахилли хэл (20хэл)

Тусламж хүсэх утасны дугаар



Гэмт хэрэг мэдэгдэх болон яаралтай дугаар	
Гэмт хэрэг мэдэгдэх (Цагдаагийн ерөнхий газар)	112
Сургуулийн хүчирхийлэл мэдэгдэх төв (Цагдаагийн ерөнхий газар)	117
Түймэр, түргэн тусламжийн өвчтөн, гэнэтийн аврах ажиллагаа (Гал хамгаалах ерөнхий газар)	119
Хакердах, залилах, хувийн мэдээлэлд халдсан талаар мэдээллэх (СИАБА)	118
Эмэгтэйчүүдийн яаралтай тусламжийн утас (Эмэгтэйчүүд, гэр бүлийн яам)	1366
Данүри дуудлагын төв (Эмэгтэйчүүд, гэр бүлийн яам)	1577-1366
Бусад өдөр тутмын санал хүсэлт	
Гадаад хүний нэгдсэн мэдээллийн төв (Хууль зүйн яам)	1345
Засгийн газрын санал хүсэлтийн дуудлагын төв (Хот төлөвлөлт, аюулгүй байдлын яам)	110
Гадаад хүний аялал жуулчлалын мэдээлэл (Солонгос аялал жуулчлалын консул)	1330
Хүний эрхэнд халдах, санал хүсэлт (Улсын хүний эрхийн нийгэмлэг)	1331
Хууль зүйн зөвлөгөө (БНСУ-н хуулийн туслалцааны цогцолбор)	132
Хүүхэд хамгааллын мэргэжлийн байгууллага (Эрүүл мэнд, нийгмийн халамжийн яам)	129
Өсвөр насныхны цахим ертөнцийн талаар зөвлөгөө (Эмэгтэйчүүд, гэр бүлийн яам)	1388

Оршин суух эрх бүхий гадаад хүнийг дэмжих бодлого



Оршин суух эрх бүхий гадаад хүнд хэрэгжүүлдэг бодлого

01 Цагдаа хууль зүйн яамтай хамт гэмт хэргийн хохирогчийг аврах ажиллагаа болон оршин суух эрх бүхий гадаад хүний эрхийг хамгаалахын тулд хууль бусаар оршин суугчийн мэдэгдлийг чөлөөлөх тогтолцоог хэрэгжүүлж байгаа.

- “Хууль бусаар оршин суугчийн мэдэгдлийг чөлөөлөх тогтолцоо” гэдэг нь хууль бусаар оршин сууж буй гадаад хүн гэмт хэргийн хохирол амссан тохиолдолд, цагдаад хохирлын талаар мэдэгдсэн ч хүчээр хилээр гаргах асуудалгүйгээр туслалцаа авах боломжтой тогтолцоо юм.

· Цагдаа хэргийг хаагдсан хойно ч хууль бусаар оршин суугчийн мэдэгдлийг хилээр орж, гарч буй гадаад иргэний байгууллагад шилжүүлэхгүй болно

- Хамрагдах гэмт хэрэг нь дараахтай адил:



Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг

Аллага, хөнөөл, хүчирхийлэл, санамсаргүйгээр хүний аминд хүрэх, хайхрамжгүй хандах, дарамт, баривчлах, хорих, сүрдүүлэх, хар тамхи хэрэглэх, уруу татах, хүчиндэх, үйл ажиллагаанд саад учруулах, хулгай, залилан.



Тусгай хуульд заасан гэмт хэрэг

Хүчирхийлэл мэтийн шийтгэлд оногдох хууль тогтоомж, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шийтгэлд оногдох тусгай хууль, зам тээврийн осол аваар зохицуулах тусгай хууль, биеэ үнэлэгчээр ажилласан явдалд оногдуулах хууль, ажлын аюулгүй байдлын (46 дугаар зүйл) зэрэг

* “Хууль бусаар оршин суугчийн мэдэгдлийг чөлөөлөх тогтолцоо” – д хамаарах хүн мөн эсэхээ хууль зүйн яамны, Гадаад хүний нэгдсэн мэдээллийн төв (1345)-ийн дуудлагаар (үйлчилгээний цаг: 09:00 – 22:00) дамжуулан мэдэх боломжтой.

